

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Жаргалант сумын 7-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/61/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2022 он	Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: А.Нарандэлгэр Утас: 70432545 цахим хаяг: narandelgera @audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Төлбөрийн акт.....	16
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ДЗОУБ	Дэлхийн зөн олон улсын байгууллага
ХАА	Худалдан авах ажиллагаа



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЖАРГАЛАНТ СУМЫН 7-Р СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.АЛТАНТУНГАЛАГ ТАНАА

2022.02.17 № 2/38
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын 7-р сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант оны элэгдлийн зардал болон тайлант үеийн үр дүн зөрүүтэй тайлагнасан, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй, түлш халаалтын зардлаас нүүрс бэлтгэхдээ ХАА зохион байгуулаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, шаардах хуудас хөтлөөгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгасан, тус байгууллагын нүүрсний зарцуулалтад тавих дотоод хяналт сул, төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулж, тайлант онд байгууллагын зүгээс нүүрсний бодит зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 1.3-д "аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам", Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 17-д Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид өгч байна" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, "Үнэн зөв байх", "Иж бүрэн байх", "Тохиолдсон байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

021020188

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>113,287,164.78</u>	<u>138,304,236.75</u>
33	АВЛАГА	-	13,599,463.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	599,463.00
335	Бусад авлага	-	13,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	13,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	113,287,164.78	124,704,773.75
351	Түүхий эд материал	4,970,350.00	5,023,078.00
35130	Эм боох материал	4,970,350.00	5,023,078.00
354	Хангамжийн материал	108,316,814.78	119,681,695.75
35420	Аж ахуйн материал	1,822,500.00	4,582,456.00
35440	Түлш, шатах тослох материал	759,000.00	1,605,000.00
35460	Хүнсний материал	-	458,370.00
35470	Бусад хангамжийн материал	105,735,314.78	113,035,869.75
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,096,633,499.69</u>	<u>4,964,562,587.70</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,096,633,499.69	4,964,562,587.70
392	Биет хөрөнгө	4,866,233,499.69	4,734,162,587.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,780,682,840.68	4,780,682,840.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	(178,348,516.20)	(296,714,459.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	234,075,889.02	243,922,693.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	(177,275,252.51)	(192,863,004.65)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	208,050,128.81	198,740,398.81
39208	Хуримтлагдсан элэгдэл	(65,879,870.05)	(72,085,246.03)
39214	Бусад үндсэн хөрөнгө	64,928,279.94	72,479,365.01
393	Биет бус хөрөнгө	230,400,000.00	230,400,000.00
39301	Програм хангамж	18,400,000.00	18,400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(18,400,000.00)	(18,400,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	230,400,000.00	230,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,209,920,664.47</u>	<u>5,102,866,824.45</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,209,920,664.47</u>	<u>5,102,866,824.45</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,209,920,664.47	5,102,866,824.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,523,546,409.40	1,523,546,409.40
51101	Өмч: - төрийн	1,523,546,409.40	1,523,546,409.40
512	Хуримтлагдсан үр дүн	2,531,087,337.61	2,424,033,497.59
51210	Өмнөх үеийн үр дүн	2,531,087,337.61	2,531,087,337.61
51220	Тайлант үеийн үр дүн	-	(107,053,840.02)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,155,286,917.46	1,155,286,917.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,209,920,664.47</u>	<u>5,102,866,824.45</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,965,418,942.65	1,847,400,417.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	153,582,542.65	31,080,161.04
120	Нийтлэг татварын бус орлого	149,996,190.65	31,080,161.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	149,996,190.65	31,080,161.04
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	680,000.00	600,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	149,316,190.65	30,480,161.04
122	Тусламжийн орлого	3,586,352.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	3,586,352.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,811,836,400.00	1,816,320,256.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,586,414,500.00	1,541,083,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,586,414,500.00	1,541,083,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,069,200.00	108,783,836.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	13,914,200.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,155,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	108,783,836.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	179,312,700.00	166,399,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	179,312,700.00	166,399,800.00
1330	Төсвийн захирагчдаас	1,040,000.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,040,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	52,720.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	52,720.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,962,861,886.33	1,953,518,481.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,962,861,886.33	1,953,518,481.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,893,564,223.33	1,812,555,157.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,304,242,379.81	1,265,160,820.00
210101	Үндсэн цалин	858,276,679.81	854,600,699.00
210102	Нэмэгдэл	337,214,400.00	337,573,121.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,630,800.00	-
210104	Урамшуулал	90,120,500.00	72,987,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	161,511,748.19	163,658,417.00
210201	Тэтгэврийн даатгал	111,186,265.19	115,075,973.53

210202	Тэтгэмжийн даатгал	13,042,600.00	12,793,090.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,434,000.00	10,227,752.30
210204	Ажилгүйдлийн даатгал	2,608,300.00	2,323,782.16
210205	Эрүүл мэндийн даатгал	24,240,583.00	23,237,818.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	158,547,700.00	158,192,284.00
210301	Гэрэл, цахилгаан	18,638,945.00	21,010,300.00
210302	Түлш, халаалт	114,412,919.00	115,034,500.00
210303	Цэвэр, бохир ус	25,495,836.00	22,147,484.00
2104	Хангамж, бараа материалын зардал	53,491,886.73	13,911,666.00
210401	Бичиг хэрэг	782,700.00	782,700.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	172,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,122,200.00	1,235,910.00
210404	Ном, хэвлэл	39,900.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	413,200.00	478,406.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	50,856,386.73	11,242,050.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	77,500.00	-
2105	Нормативт зардал	29,621,553.00	34,340,803.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,693,250.00	6,628,800.00
210502	Хоол, хүнс	23,344,903.00	24,936,153.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,583,400.00	2,775,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,105,250.00	5,174,800.00
210604	Урсгал засвар	4,105,250.00	5,174,800.00
2107	Томилолт, зочны зардал	224,000.00	-
210702	Дотоод албан томилолт	224,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	767,000.00	4,844,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,836,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	767,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	181,052,705.60	167,272,367.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,614,750.00	392,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,328,679.80	12,612,141.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	148,109,275.80	154,268,026.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,297,663.00	140,963,324.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,092,000.00	140,678,858.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	52,720.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,092,000.00	46,557,850.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	91,743,288.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,325,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,205,663.00	284,466.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,205,663.00	284,466.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,557,056.32	(106,118,064.74)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,172,662.36	935,775.28
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,172,662.36)	(935,775.28)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,384,393.96	(107,053,840.02)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,523,546,409.40	1,155,286,917.46	2,531,087,337.61	5,209,920,664.47
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,523,546,409.40	1,155,286,917.46	2,531,087,337.61	5,209,920,664.47
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(106,651,549.62)	(106,651,549.62)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,523,546,409.40	1,155,286,917.46	2,424,435,787.99	5,103,269,114.85
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,523,546,409.40	1,155,286,917.46	2,424,435,787.99	5,103,269,114.85
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,523,546,409.40	1,155,286,917.46	2,424,435,787.99	5,103,269,114.85
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(107,053,840.02)	(107,053,840.02)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,523,546,409.40	1,155,286,917.46	2,317,381,947.97	4,996,215,274.83

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,812,516,400.00	1,816,920,256.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	680,000.00	600,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	680,000.00	600,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	680,000.00	600,000.00
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	680,000.00	600,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,811,836,400.00	1,816,320,256.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,586,414,500.00	1,541,083,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,586,414,500.00	1,541,083,900.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,069,200.00	108,783,836.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	13,914,200.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,155,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	108,783,836.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	179,312,700.00	166,399,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	179,312,700.00	166,399,800.00
1330	Төсвийн захирагчдаас	1,040,000.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,040,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	52,720.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	52,720.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,812,516,400.00	1,816,920,256.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,812,516,400.00	1,816,920,256.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,743,218,737.00	1,678,281,932.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,304,230,626.00	1,259,399,700.00
210101	Үндсэн цалин	858,264,926.00	854,468,900.00
210102	Нэмэгдэл	337,214,400.00	331,943,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,630,800.00	-
210104	Урамшуулал	90,120,500.00	72,987,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	161,511,748.00	170,019,000.00
210201	Тэтгэврийн даатгал	111,186,265.00	119,643,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	13,042,600.00	12,594,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,434,000.00	10,075,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,608,300.00	2,518,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,240,583.00	25,188,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	167,329,700.00	161,363,284.00
210301	Гэрэл, цахилгаан	18,638,945.00	21,010,300.00
210302	Түлш, халаалт	123,194,919.00	118,205,500.00
210303	Цэвэр, бохир ус	25,495,836.00	22,147,484.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,294,200.00	11,662,948.00
210401	Бичиг хэрэг	782,700.00	1,484,520.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	172,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,122,200.00	1,122,200.00

210404	Ном, хэвлэл	767,900.00	558,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	413,200.00	2,316,928.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,008,200.00	6,008,200.00
2105	Нормативт зардал	35,049,063.00	34,721,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,172,000.00	3,958,800.00
210502	Хоол, хүнс	21,911,663.00	25,417,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,965,400.00	5,345,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,983,000.00	6,143,000.00
210604	Урсгал засвар	11,983,000.00	6,143,000.00
2107	Томилолт, зочны зардал	224,000.00	-
210702	Дотоод албан томилолт	224,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	767,000.00	11,448,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	10,440,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	767,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,829,400.00	23,524,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,485,000.00	13,600,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	54,344,400.00	9,924,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,297,663.00	138,638,324.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,092,000.00	138,353,858.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	52,720.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,092,000.00	46,557,850.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	91,743,288.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,205,663.00	284,466.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,205,663.00	284,466.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	=
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	=
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,715,083,716	1,707,799,234
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,715,083,716	1,707,799,234
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,668,294,916	1,661,241,384
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,259,399,700	1,259,399,700
210101	Үндсэн цалин	854,468,900	854,468,900
210102	Нэмэгдэл	331,943,800	331,943,800
210104	Урамшуулал	72,987,000	72,987,000
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	170,019,000	170,019,000
210201	Тэтгэврийн даатгал	119,643,000	119,643,000
210202	Тэтгэмжийн даатгал	12,594,100	12,594,100
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,075,100	10,075,100
210204	Ажилгүйдлийн даатгал	2,518,800	2,518,800
210205	Эрүүл мэндийн даатгал	25,188,000	25,188,000
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	168,416,816	161,363,284
210301	Гэрэл, цахилгаан	21,010,300	21,010,300
210302	Түлш, халаалт	122,260,016	118,205,500
210303	Цэвэр, бохир ус	25,146,500	22,147,484
2104	Хангамж, бараа материалын зардал	9,057,400	9,057,400
210401	Бичиг хэрэг	782,700	782,700
210402	Тээвэр, шатахуун	172,600	172,600
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,122,200	1,122,200
210404	Ном, хэвлэл	558,500	558,500
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	413,200	413,200
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,008,200	6,008,200
2105	Нормативт зардал	34,721,900	34,721,900
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,958,800	3,958,800
210502	Хоол, хүнс	25,417,700	25,417,700
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,345,400	5,345,400
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,983,000	4,983,000
210604	Урсгал засвар	4,983,000	4,983,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,008,000	1,008,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000	1,008,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,689,100	20,689,100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,600,000	13,600,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,089,100	7,089,100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,788,800	46,557,850
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,788,800	46,557,850
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	46,788,800	46,557,850
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,715,083,700	1,707,799,234
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,541,083,900	1,540,852,966

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,541,083,900	1,540,852,966
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	173,399,800	166,346,268
132001	Орон нутгийн төсвөөс	173,399,800	166,346,268
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	600,000	600,000
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000	600,000
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	110	111
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	69	70
620003	Үйлчлэх ажилтан	40	40
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	110	111
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	70	71
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1	1
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	1
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	38	38

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,069,200.00	108,783,836.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	45,069,200.00	108,783,836.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,069,200.00	17,040,548.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2,605,548.00
210401	Бичиг хэрэг	-	701,820.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,903,728.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,160,000.00
210604	Урсгал засвар	-	1,160,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	10,440,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	10,440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,069,200.00	2,835,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	845,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	44,224,200.00	2,835,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	91,743,288.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	91,743,288.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	91,743,288.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	45,069,200.00	108,783,836.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,069,200.00	108,783,836.00

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,040,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,155,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,264,000.00	108,783,836.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,610,200.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын 7-р сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн зарцуулалт, дотоод хяналттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор А.Нарандэлгэр 2022 оны 01 дүгээр сарын 24-нээс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд аймгийн Жаргалант сумын 7-р сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд “Сургууль, багш, эцэг, эхийн хамтын ажиллагааг өргөжүүлж сурагчдын сурлага, хөгжил, төлөвшилд ахиц гаргаж, хүнлэг энэрэнгүй иргэнийг төлөвшүүлэх” зорилгын хүрээнд 9 зорилт, 5 цогц арга хэмжээний 42 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 237-р тогтоолоор “үдийн цай” хөтөлбөр “үдийн хоол” болж өөрчлөгдсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Ховд аймгийн Жаргалант сумын 7-р сургууль тус байгууллагад дотоод хяналтын баг санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны Үр дүнгийн тайлангийн 1,953,117.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон 29,296.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 20,507.7 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ховд аймгийн Жаргалант сумын 7-р сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 106,651.5 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Тайлант онд авлага 13,599.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Санко Маркетинг Монголиа ХХК-тай ухаалаг салбар нийлүүлэх гэрээ хийж, 13,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн, ажиллагчидтай холбоотой авлага 599.5 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 124,704.7 мянган төгрөг болж 11,417.6 мянган төгрөгөөр буюу хандиваар, БШУГ, ДЗОУБ, төсөл хөтөлбөрөөр бараа материал шилжиж ирсэнтэй холбоотойгоор өссөн байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 171,102.8 мянган төгрөг, үнэ төлбөргүйгээр 17,720.6 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 177,405.8 мянган төгрөгийн материалыг зарцуулж, аймгийн БОЭТ-д 8,500.0 мянган төгрөгийн бараа материал шилжүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 5,096,633.5 мянган төгрөг, оны эцэст 4,964,964.9 мянган төгрөг болж 131,668.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардал болон хөрөнгө акталсантай холбоотой байна.

Тайлант онд 10,373.4 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 12,759.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 15,044.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 5,209,920.6 мянган төгрөг байсан оны эцэст 5,103,269.1 мянган төгрөг болж тайлант онд 106,651.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 2,424,435.8 мянган төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Ховд аймгийн Жаргалант сумын 7-р сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээр 1,752,317.9 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 191,042.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,943,360.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 1,734,283.7 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1,715,083.7 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээр 1,541,083.9 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 173,399.8 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 1,540,799.4 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 166,399.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,707,799.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,707,799.2 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь Байр ашиглалттай тогтмол зардлыг 7,035.5 мянган төгрөгөөр, Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 230.9 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны байгууллагаас Багш нарын тэтгэмжийн зардалд 91743.3 мянган төгрөгийн, А/30 тоот захирамжаар сургууль, дотуур байрны ариутгалын зардалд 698.7 мянган төгрөгийн, А/452 тоот захирамжаар өвөлжилтийн бэлтгэл хангах, ариутгалын зардалд 2205.0 мянган төгрөгийн, А/280 тоот тушаалаар тэтгэлэгт хөтөлбөрийн 10600.0 мянган төгрөгийн, А/551, А/48 тоот захирамжуудаар 3536.8 мянган төгрөгийн, нийт 108,783.8 мянган төгрөгийн санхүүжилтийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн дээрх эх үүсвэрүүдийг холбогдох арга хэмжээнд зарцуулжээ.

Нэмэлт дансны төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийг 98.3 хувьтай мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 100 хувь хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал нь түлш халаалтын зардлын зарцуулалт, нүүрс худалдан авах тендерийг зарласан эсэхийг дахин хянан авч үзэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 274 911.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,929.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 650.1 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 116,630.5 мянган төгрөгийн албан шаардлага, 153,701.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тайлант оны элэгдлийн зардал болон тайлант үеийн үр дүн зөрүүтэй тайлагнасан 1,604.8 мянган төгрөг,
2. Байгууллагын түлш халаалтын зардлаас нүүрс худалдан авч ажилчдад түлээ, нүүрсний тусламж олгон түлш халаалтын зардлаар тайлагнасан 2,325.0 мянган төгрөг,

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 3,929.8 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан 2022 оны 02 дугаар сарын 09-ны 11 тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

4.2 Төлбөрийн акт

1. Бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй, үдийн цайны зардлаас Бүрэгтэй ХХК-ны харилцах данс руу нэхэмжлэлээс илүү дүнгээр шилжүүлсэн 331.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах" гэсэн хуулийн заалт, аудитын "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. ЗГ-ын шагналаар шагнагдсан албан хаагчдад 318.6 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон зөрчил илэрсэн нь 2019 оны Засгийн газрын 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.7-д "Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн 2 акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1. Түлш халаалтын зардлаас нүүрс бэлтгэхдээ ХАА зохион байгуулаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, шаардах хуудас хөтлөөгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгасан 116,630.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 Түлш халаалтын зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт 1:

Байгууллагын нүүрсний бодит зарцуулалтыг хянах зорилгоор ажлын байрны зураг авалт хийхэд дутуу шатсан нүүрс ихтэй үнсийг зайлуулсан ба түүнийг нь ойр орчмын иргэд ачиж авахдаа нүүрстэй хамт авсан байж болзошгүй үйлдэл илэрсэн, нүүрсний зарцуулалт хэт үрэлгэн, тог, ус тасарсан гэж дотоод хяналтын тайланд бичигдсэн ч Шим ус ОНӨААТҮГ, Цахилгаан түгээх сүлжээ ХХК-с тодруулахад тухайн хугацаанд тог, ус тасраагүй болохыг нотолж ирүүлсэн болно.

Мөн тус байгууллагын халаалтын тогооны ашиглалтын талаар МХГ-ын байцаагчийн дүгнэлт гарсан ч солих арга хэмжээ аваагүй байна.

Дээрх алдаа зөрчлөөс үзэхэд тус байгууллагын нүүрсний зарцуулалтад тавих дотоод хяналт сул, төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулж, тайлант онд байгууллагын зүгээс нүүрсний бодит зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 1.3-д "аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна", 1.5-д "... Журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам" тухайн байгууллага, аж ахуйн

нэгж өөрөө баталж мөрдөнө" зэрэг заалтуудыг баримтлан ажиллаж түлш халаалтын зардлыг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулах талаар тодорхой үе шаттай ажлуудыг хэрэгжүүлэх

4.4.1 Засгийн газрын 43 тоот тогтоолтой холбоотой асуудал

Илрүүлэлт1: Тайлант баталсан орон тоог 1-ээр нэмэгдүүлсэн, батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй 153,701.1 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын холбогдох заалтуудыг баримталж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жаргалант сумын 7-р сургууль	7	274,911.6	2	3929.8	2	650.1	1	116,630.5	2	153701.1

Ховд аймаг дахь Төрийн аудитын газар